



УВС ХҮНС ХК

2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



"УВС ХҮНС" ХК нь 2018 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөтгөх, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилтын хүрээнд 400 гаруй сая төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг хийж хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн, эрүүл аюулгүй орчинг бүрдлээ. Хувьцаа эзэмшигч, харилцагч Та бүхэнд компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- 2018 онд Талх, нарийн боовны шинэ цехийн засварын ажлыг дуусгаж, 100 сая төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийв. Талх нарийн боовны цехийг нүүлгэн шилжүүлэв.



- 2018 оны 11-р сард Талх, нарийн боовны үйлдвэрлэлийн байрыг шинэчлэн ашиглалтанд оруулж, ХБНГерман улсаас талх, нарийн боовны мэргэжилтэнг үйлдвэр дээрээ урин ажиллуулж, 14 хоногийн хугацаатай сургалт явуулснаар 20 гаруй шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаанд гаргалаа.



- "УВС ХҮНС" ХК-ний нэрийн барааны Агуулах дэлгүүрийг өөртөө үйлчлэх "UFood's" маркет өргөтгөж, хэрэглэгчдийг илүү өргөн сонголттойгоор худалдан авалт хийж боломжийг олгож, борлуулалтыг нэмэгдүүлэх алхамыг хийв.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- Хуучин Агуулах дэлгүүрийг Гурил, тэжээлийн агуулах худалдаа болгож өөрчилж, “Баянцагаан” гурил, хорголжин тэжээл, хивэг, овъёос худалдаалж байна.



- Гурил, тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотойгоор гурил, тэжээлийг нөөцлөх агуулахын барилгыг 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулсан.



- Бэлэн бүтээгдэхүүн хадгалах хөргүүрийг 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж ашиглалтанд оруулсан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эх, үрсийн баярыг угтан зохион байгуулагдсан “Өглөө бүр шинэхэн” гар зураг, шүлгийн уралдаан 2,5 сая төгрөгийн шагналын сантайгаар зохион байгуулагдсан. Уралдаанд Улаангом сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 200 гаруй сурагчийн, 500 гаруй бүтээл ирсэн.

Уралдааны бага, дунд, ахлах ангийн төрөлд шилдэг бүтээлээр шалгарсан сурагчид унадаг дугуйтай болохын зэрэгцээ оролцсон сурагч бүр компаний нэрийн бэлэг авсан юм.



Улаангом сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 9 дүгээр ангийн 24 төгсөгчдөд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилготой танилцах аялалын “Ирээдүйн эзэд - “УВС ХҮНС” ХК-ний чацарганы жүүсийг сонгож байна”.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 онд чацарганы ургац хураалтанд нийт 150 гаруй хүнийг түр ажлын байраар ханган ажиллуулж, 60 гаруй тонн чацаргана жимс хураан авлаа. Хамтран ажиллагч, бэлтгэн нийлүүлэгчдээс 40 гаруй тонн худалдан авч, 100 тонн жимсийг боловсруулсан.



Чацарганы ургац хураалтын үеэр компаний үйл ажиллагаа болон чацарганы жимсний ургац хураалтын үйл явцтай танилцахаар Улаанбаатар хотын "Шинэ эрин" сургуулийн ахлах ангийн сурагчид 7 хоногийн хугацаатай танилцах аялал зохион байгуулагдсан. Энэ хугацаанд сурагчид “УВС ХҮНС” ХК-ний үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ монгол гэр хэрхэн барих талаар суралцах, хотон ястны өв соёлтой танилцах, Элит сортын 100 га чацарганы плантаци дээр өөрийн биеэр чацаргана хураалтын үйл явцад оролцлоо. Багш, сурагчдыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах үеэр сурагчдын түүсэн жимсийг хэрхэн боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн бүтээж байгаа талаар дэлгэрэнгүй үзүүлж, танилцууллаа.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Увс түншлэл - 2018" үзэсгэлэнгээс манай компанийн Чацарганы "Үрийн тос" импортыг орлох бүтээгдэхүүн шагнал, Увс аймгийн ХАҮТ-ын "Чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч шилдэг байгууллага" -аар шалгарлаа.




**САНХҮҮГИЙН
БАЙДЛЫН ТАЙЛАН**
САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /мян.төг/

Үзүүлэлт	2018 он	Өсөлт
Нийт хөрөнгө	3,860,684	16%
Өр төлбөрийн нийт дүн	1,893,112	17%
Эзэмшигчдийн өмчийн дүн	1,967,572	16%

ОРЛОГЫН ТАЙЛАН
ОРЛОГО , ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ/мян.төг/

Үзүүлэлт	2018 он	Өсөлт
Борлуулалт	2,482,801	56%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,502,876	54%
Үйл ажиллагааны зардал	691,063	26%
Цэвэр ашиг	274,418	319%

2018 оны санхүүгийн үзүүлэлт өмнөх оноос
/мян. төг/



2018 онд архин бүтээгдэхүүний үйлдвэрлэл 32 хувь, талх, нарийн боовны үйлдвэрлэл 24 хувь, чацаргана боловсруулах үйлдвэрлэл 91 хувь, цэвэр усны үйлдвэрлэл 26 хувиар тус тус өссөн байна.